

**БАТЛАВ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Ү.ТӨМӨРХУЯГ

Огноо: 2020 оны 5 Дугаар сарын 26

ТӨРӨЛ БҮРИЙН ГУРИЛ 2 БАГЦ НИЙЛҮҮЛЭХ

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

ДЦС4/2020-280

1-р багц Гурил дээдийн дээд

2-р багц Гурил бүтэн үрийн, арвайн

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) ТООЗ-д заасан шаардлагууд |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн тайлан 2019 он, • компанийн гэрчилгээний хуулбар, • тусгай зөвшөөрлийн хуулбар, туршлагын мэдээлэл, ирүүлнэ. • НӨАТ-ийн гэрчилгээ • Татварт өргүй гэсэн цахим татварын тодорхойлолт
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 06 дугаар сарын 03 –ны өдөр Цаг: 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот.Баянгол дүүрэг. 20-р хороо. “ДЦС-4” ТӨХК. Давхар болон өрөөний дугаар: 310 тоот Огноо: 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ДЦС4/2020-280 1-р багц Гурил дээдийн дээд төсөв 25,614,428.0 төгрөг</p> <p>2-р багц Гурил бүтэн үрийн, арвайн төсөв 2,017,725.0 төгрөг нийлүүлэх хоёр багцаас бүрдэнэ.</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Багц 1 Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь								
№	Нэр	Тоо	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүл эх эхний хугацаа	Нийлүүл эх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа	
1	Гурил дээдийн дээд	4800	кг	"ДЦС-4" ЭЗГ-н агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралта ар нэгж үнийн санал ирүүлнэ
2	Гурил дээд	16288	кг	"ДЦС-4" ЭЗГ-н агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралта ар нэгж үнийн санал ирүүлнэ

Багц 2 Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь								
№	Нэр	Тоо	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			Тайлбар
					Нийлүүл эх эхний хугацаа	Нийлүүл эх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа	
1	Гурил 2-р	1152	кг	"ДЦС-4" ЭЗГ-н агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралта ар нэгж үнийн санал ирүүлнэ
2	Гурил бүтэн үрийн	802	кг	"ДЦС-4" ЭЗГ-н агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралта ар нэгж үнийн санал ирүүлнэ
3	Гурил арвайн	40	л	"ДЦС-4" ЭЗГ-н агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралта ар нэгж үнийн санал ирүүлнэ

БУУДАЙН ГУРИЛАНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Буудайн гурил нь MNS 0244:2009, MNS 0244:2003 стандартын шаардлагад нийцсэн БГ-045, БГ-050, БГ-055, БГ-075, БГ-140 ангилалтай байна. Гурилыг MNS SAC/RCP 1:2003 Хүнсний ерөнхий зарчим стандартын шаардлага хангасан үйлдвэрт аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан батлагдсан технологийн зааврын дагуу үйлдвэрлэнэ.

Гурилын мэдрэхүйн үзүүлэлт Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Шинж чанар, ангиллаар	
		БГ-045, БГ-050, БГ-055	БГ-075 БГ 140
1	Өнгө	Цайвар шаргал туяатай цагаан	Цагаан саарал, шаравтар туяатай цагаан, цагаан цаарал
2	Үнэр	Буудайн гурилын хэвийн үнэртэй, хөгзний буюу исгэлэн үнэргүй байна.	
3	Амт	Буудайн гурилын хэвийн амттай, исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй байна.	
4	Эрдэс хольц	Зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл мэдрэгдэхгүй байх	

Гурилын физик химийн үзүүлэлт Хүснэгт 2

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ			
			БГ-045	БГ-055	БГ-075	БГ140
1	Чийглэг, ихгүй	%	15,5	15,5	15	15,5
2	Үнслэг, ихгүй	%	0,55	0,55	0,75	1,15
3	Ширхэгжилт,үлдэц, ихгүй	%	5,0	5,0	3,0	2,0
4	Капрон шигшүүрийн дугаар	№	43	43	38	32
		микрон	160	160	180	219
5	Нойтон цавуулаг, багагүй	%	23,0	23,0	26,0	25,0
6	Цавуулгын чанар, ИДК-ийн заалт,бүлгээр, доошгүй	Нэгж	20-100 II	20-100 II	20-100 II	200-300 II
7	Хүчиллэг, ихгүй	°Н	3,5	3,5	3,8	4,5
8	Төмөрлөг хольц (цайр, төмрөөс бусад), ихгүй	Мг/кг	3	3	3	3
9	Аминдэм, эрдсийн агуулга В ₁ /тиамин/ В ₂ /рибофлавин/ В ₃ /ниацин/ В ₉ /фолийн хүчил/ Төмөр Цайр Д ₃ холекальциферол	Мг/кг	1,3-1,5 2,0-2,3 6,7-7,7 1,3-1,5 30,0-34,5 18,7-21,5 0,0250-0,0288			

Гурилын эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлт Хүснэгт 3

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хортон шавж, өндөг, авгалдай	-	Илрэх ёсгүй
Микробиологийн үзүүлэлт -Төмсний савханцар, 1г гурилд, ихгүй	Тоо (CFU)	200
Гэдэсний бүлгийн эмгэг төрүүлэгч нян	-	Илрэх ёсгүй
Хүнд металл -Кадми -Хар тугалга	Мг/кг	0,2 0,2
Пестицидын үлдэгдэл	Мг/кг	MNS5868
Микотоксин “ Зеарогенон”, 1кг	мг	1,0

гурилд ихгүй		
Цэцрагын бохирдол	-	Илрэх ёсгүй

Гурилын савлалт хаягалалт

Гурилыг зориулалтаар нь ангилан “ Гурилын шуудай MNS 2515:1994”-ийн шаардлага хангасан шуудай, уутанд 25 кг хүртэл жинтэйгээр жижиглэн савлаж амсрыг битүүмжилнэ. Савласан гурилын жингийн хэлбэлзэл $\pm 1,0\%$ -иас ихгүй байна. Гурилын тухайн үеийн чийглэгийн хэмжээнээс хамааруулан чийглэгийн зөрүүгээр жингийн нэмэгдэл, хорогдлыг тооцно.

Савласан гурилын шуудай, уут бүр нь “ Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр хаяг
- Бүтээгдэхүүний нэр
- Бүтээгдэхүүний цувралын дугаар
- Стандартын дугаар
- Үйлдвэрлэсэн огноо, хүчинтэй хугацаа
- Хэрэглэх заавар, хэмжээ
- Бүтээгдэхүүний найрлага

Хадгалалт тээвэрлэлт

Буудайн гурилыг агаарын солилцоо сайтай, 15 °C-с ихгүй температур, 60%-с ихгүй агаарын харьцангуй чийглэгтэй шороо чийгээс бүрэн хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална. Гурилыг үйлдвэрлэсэн өдрөөс хойш нэг жилээс дээшгүй хугацаагаар хадгална. Гурилыг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гаднаы үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, шороо, чийгээс хамгаалсан бүрхүүлтэй байна

АРВАЙН ГУРИЛАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Арвайн гурил нь MNS 2091:1997 стандартын шаардлагад нийцсэн байна. Гурилыг MNS 3810:85 стандартын дагуу хальстай болон нүцгэн үрт арвайгаар үйлдвэрлэнэ. Арвайн гурилыг эрүүл ахуй, ариун цэвэр, хангасан үйлдвэрт холбогдох байгууллагаар батлуулсан техникийн баримт бичгийг мөрдөж үйлдвэрлэнэ.

Мэдрэхүйн эрхтний үнэлгээ Хүснэгт 1

Үзүүлэлт	Гурилын шинж чанар
1. Гадаад байдал	Жигд жижиг ширхэгтэй гурилхархаг нунтаг
2. Өнгө	Цайвар бор
3. Амт, үнэр	Арвайн гурилны өвөрмөц сайхан амт үнэртэй, исгэлэн, түлэнхий буюу гадны үнэр амтгүй байна.
4. Эрдэс хольц	Шүдэнд мэдэгдэх элсэрхэг хатуу хольцгүй байна.

Хүснэгт

Физик, химийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Чийглэг, ихгүй	%	9
2	Үнслэг, ихгүй	%	2,3
3	Тос	%	2,3
4	Эслэг	%	4,4
5	Цардуул, г	гр	48,1

Гурилын эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлт

Хүснэгт 3

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хортон шавж, өндөг, авгалдай	-	Илрэх ёсгүй
Микробиологийн үзүүлэлт -Төмсний савханцар, 1г гурилд, ихгүй	Тоо (CFU)	200
Гэдэсний бүлгийн эмгэг төрүүлэгч нян	-	Илрэх ёсгүй
Хүнд металл -Кадми -Хар тугалга	Мг/кг	0,2 0,2
Пестицидын үлдэгдэл	Мг/кг	MNS5868
Микотоксин “ Зеарогенон”, 1кг гурилд ихгүй	мг	1,0
Цэцрагын бохирдол	-	Илрэх ёсгүй

Гурилын савлалт хаягалалт

Савласан гурилын шуудай, уут бүр нь “ Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих ерөнхий шаардлага” MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр хаяг
- Бүтээгдэхүүний нэр
- Бүтээгдэхүүний цувралын дугаар
- Стандартын дугаар
- Үйлдвэрлэсэн огноо, хүчинтэй хугацаа
- Хэрэглэх заавар, хэмжээ
- Бүтээгдэхүүний найрлага

Хадгалалт тээвэрлэлт

Буудайн гурилыг агаарын солилцоо сайтай, 15 °C-с ихгүй температур, 60%-с ихгүй агаарын харьцангуй чийглэгтэй шороо чийгээс бүрэн хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр эгнүүлэн хурааж хадгална. Гурилыг үйлдвэрлэсэн өдрөөс хойш нэг жилээс дээшгүй хугацаагаар хадгална. Гурилыг зөөх тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гаднаы үнэргүй, хортон шавьжаар бохирдоогүй, шороо, чийгээс хамгаалсан бүрхүүлтэй байна.

Дөрөв. Төрөл бүрийн гурил Багц 1,2 нийлүүлэх үнийн саналын маягт

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нэгж үнийг тооцоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [нэг] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах болон турших (ГЕН – 1)**
 - 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
 - 1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана

2. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
 - 2) барааны гарал үүслийн гэрчилгээ.

3. **Баталгаат засвар (ГЕН-5)**
 - 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

4. **Төлбөр (ГЕН – 7)**
 - 7.1. Нийлүүлэгчид **Урьдчилгаатөлбөр** олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг хийнэ.

5. **Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**

Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн **30%-аас** хэтрэхгүйбайна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

ЗАХИРАЛ

ТӨРӨЛ БҮРИЙН ГУРИЛ БАГЦ 1,2 НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **“ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны ___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь ТӨРӨЛ БҮРИЙН ГУРИЛ БАГЦ 1,2 **нийлүүлэх ДЦС4/2020-280** (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 1 жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

2. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.

4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХААХ-ИЙН ДАРГА:

О.ГАНТӨМӨР

ЭЗГ-ИЙН ДАРГА:

Я.ГЭРЭЛМАА

“.....” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР

.....

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ч.БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД